



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 02 сарын 11 өдөр

Дугаар А/20

Улаанбаатар хот

Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл
нийлүүлэгчийг сонгон шалгаруулах
үнэлгээний хороо байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.10, 8 дугаар 8.3.1, 8.4, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 заалт, 47 дугаар зүйлийн 47.1, 47.4 дэх хэсэг, "Босго үнэ шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан төсвийн хүрээнд худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулан ажиллахыг Үнэлгээний хороо (П.Буяндэлгэр)-д үүрэг болгосугай.


3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавихыг Захиргаа, удирдлагын газар (Л.Намхайноров)-т үүрэг болгосугай.

4.Үнэлгээний хороонд ажиллах ажилтнуудын "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх мэдэгдэл"-ийг гаргуулан байгууллагын ЭБАТ-д бүртгүүлж, худалдан авах ажиллагаатай холбогдох баримт бичгээр архивын нэгж үүсгэж, холбогдох албан тушаалтад хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Ж.Халиунаа)-д үүрэг болгосугай.

ДЭД ДАРГА, ДАРГЫН ҮҮРГИЙГ
ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ Д.УРАНЗАЯА



Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын
газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 11-ны
өдрийн 4 дугаар тушаалын хавсралт



**ЭМ, БЭЛДМЭЛ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ
СОНГОН ШАЛГАРУУЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч : П.Буяндэлгэр (ЭЭХХЗГ, ЭТТГ -ын дарга)

Гишүүд:

М.Энхжаргал (ЭЭХХЗГ, ЗУГ-ын мэргэжилтэн)

Б.Батжаргал (Эрүүл мэндийн технологи
инновацийн хамтын ажиллагааны хүрээлэн
НҮТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүн)

Т.Отгонтөгс (Сэтгэлд мөнхрөх үйлс ТББ-ын
зохицуулагч)

Нарийн бичгийн дарга: Ж.Халиунаа (ЭЭХХЗГ, ЭТТГ-ын мэргэжилтэн)